

ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ХҮН АМЫН ЭРҮҮЛ МЭНД, ЭМНЭЛГИЙН ТУСЛАМЖ

ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТОВЧ МЭДЭЭЛЭЛ

/2021 оны 2 сарын байдлаар/

№	Үзүүлэлт	<u>БОЭТ</u>	<u>Сумдын эмнэлэг</u>	<u>Өрхийн эмнэлэг</u>	<u>Хувийн эмнэлэг</u>	<u>Цэргийн анги</u>	<u>Нийт дүн</u>
1	Нийт үзлэг	14894	18165	11727	9522	1136	55444
2	Урьдчилан сэргийлэх үзлэг	5052	6272	4408	2073	1049	18854
3	Идэвхтэй хяналтын үзлэг	1627	4122	3410	876		10035
4	Бүртгэгдэж эмчлэгдсэн өвчлөл	5430	3826	1258	2054	89	12657
5	Нийт төрөлт	203	65				268
6	Хэвтэн эмчлүүлэгчид	1122	593		594	12	2321
7	Нас баралт	2	20	11			33

№	Үзүүлэлт	<u>2020.2</u>	<u>2021.2</u>	<u>Өөрчлөлт</u>
1	Нийт үзлэг	52256	55444	3188
2	Урьдчилан сэргийлэх үзлэг	9635	18854	9219
3	Идэвхтэй хяналтын үзлэг	9531	10035	504
4	Бүртгэгдэж эмчлэгдсэн өвчлөл	14400	12657	-1743
5	Нийт төрөлт	299	268	-31
Үүнээс	Гэрийн төрөлт	2	2	0
	Охидын төрөлт	13	15	2
	Охидын төрөлтийн эзлэх хувь	4,3	5,6	1,3
6	Хэвтэн эмчлүүлэгчид	2953	2321	-632
7	Нас баралт	59	33	-26
	0-1 насны эндэгдэл	5	2	-3
	1-5 насны эндэгдэл	0	0	0
	Хурц халдварт өвчин	87	7	-80

Үзүүлэлт	хэмжих нэгж	2010.2 сар	2021.2 сар	өөрчлөлт
Нялхасын эндэгдэл	1000 амьд төрөлтөд	16.6	7.5	-9.1
Үр хөндөлт	1000 амьд төрөлтөд	335.5	363.2	27.7
Үүнээс охидын	хувь	7.9	13.4	5.5
Хурц халдварт өвчин	10000 хүн амд	12.4	0.9	-11.5
БЗДХ	10000 хүн амд	7.3	2.9	-4.4
Үүнээс өсвөр үе	хувь	5.8	23.8	18
Хүүхдийн хяналт /0-1 нас/	хувь	72	78	6
Хүүхдийн хяналт /1-5 нас/	хувь	47	46.4	-0.6

I. ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭ

- Улсын болон хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагууд нийт 55444 хүнд үзлэг шинжилгээ хийсний 52.1%-д нь урьдчилан сэргийлэх болон идэвхтэй хяналт тандалтын үзлэг хийгдсэн байна.
- Ортой эмнэлгүүдэд нийт 2321 хүнийг 14767 ор хоногоор хэвтүүлэн эмчилсэн нь нэг хүн дунджаар 6.3 хоног хэвтэн эмчлүүлсэн байна.
- Түргэн тусламжийн 1698 дуудлагад явж үйлчилсний 255/15%/ нь алсын дуудлага, 175/10.3%/нь осол гэмтлийн яаралтай дуудлага байсан байна. Нийт дуудлагын 83,3% -д 0-20 минутны дотор гарч үйлчилсэн байна .

- Нийт эмийн сангууд 12516 жор хүлээн авч, 1тэрбум 176 сая төгрөгний эм бараа борлуулалт хийсэн байна.
- ЭЭСангуудад нийт 2498 жор ирсний 55,6% /1391/ нь ЭМДаатгалын, 3.2%/82/ мансууруулах сэтгэц нөлөөт эмийн, 41% /1025/ нь энгийн эмийн жор байсан байна. Зайлшгүй шаардлагатай эмийн хангалт дундажаар 67,5% байна.

II. БҮРТГЭГДСЭН ӨВЧЛӨЛ, ЭНДЭГДЭЛ

- 2 сарын байдлаар 12657 халдварт бус өвчлөл шинээр бүртгэгдэж эмчлэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 1743 тохиолдлоор буурсан байна. Нийт өвчлөлийн 60,4% нь шинэ өвчлөл байна.
- **Үүнээс тэргүүлэх 5 өвчлөл нь:**
 1. **Хоол шингээх эрхтний өвчин-3652** /46% шүдний цоорол, 15% ходоодны, 9% элэгний үрэвсэл/
 2. Цусны эргэлтийн тогтолцооны өвчин-1713 /Артерийн даралт ихдэх 57%, зүрхний ишемит өвчин 26,5%/
 3. Шээс бэлэгсийн тогтолцооны өвчин-1451
 4. Амьсгалын тогтолцооны өвчин-1422
 5. Мэдрэлийн тогтолцооны өвчин-1095
- 2 сарын байдлаар 272 хүн осол гэмтэлд өртсөний улмаас тусламж авсан ба осол гэмтлээр 7 хүн нас барсан нь өнгөрсөн оноос 1-р, өвчлөл 70 тохиолдлоор өссөн байна.
- Осол гэмтлээр нас барагсдын 14,2%/1/нь амиа хорлосон-/Мн-1/,42,8% /3/нь зам тээврийн осол-/Гт-1,Нн-1,Өо-1, / 42,8% /3/ нь бусад ослоор /Бо-1, Цц-2/ тус тус эндсэн байна.
- Осол гэмтлээр нас барагсад нь 71,4% /5/ эрэгтэй ба 1 нь эмнэлэгт хүргэгдсэн боловч хоног болоогүй нас барсан байна. Бусад тохиолдлууд эмнэлгийн ямар нэг тусламж авч чадаагүй газар дээрээ нас барсан байна.
- Оны гарсаар 33 хүн нас барсан ба нийт нас барсан хүний 31,8% нь осол гэмтлээр, 15,1% нь хорт хавдраар, 3% нь зүрхний шигдээс, тархинд цус харвалт зэрэг сэргийлж болох эндэгдэлээр, 3% нь нярай үеийн эмгэгийн улмаас нас барсан байна. Нийт нас баралтын 4 нь эмнэлэгт, бусад нь гэртээ, хээр гадаа нас барсан байна.
- Нялхсын эндэгдлийн 2 /Но-1,БОЭТ-1/ тохиолдол бүртгэгдсэн нь 1000 амьд төрөлтөд 7,5% байна.
- Нялхсын эндэгдэл 2020 онд 60% нь эрт нярайн эндэгдэл байсан бол 2021 онд мөн 50% нь эрт нярайн, 50% нь сараас дээш насны хүүхэд 1 байгаа ба хатгаагаар эндсэн байна
- БОЭТөвд 2 эндэгдэл тохиолдож задлан шинжилгээ 50% тай байна. Үндсэн оношийн зөрөө байхгүй.
- **Нас баралтын шалтгаан:**
 1. **Цусны эргэлтийн тогтолцооны өвчин-13**
 2. Бэртэл хордлого гадны шалтгаант нас баралт-7
 3. Хорт хавдарын нас баралт-5
 4. Хоол шингээх эрхтний өвчин-4
 5. Төрөх, перинаталь үед үүсэх эмгэг-1/ нярай/
 6. Бөөрний эмгэг 1
 7. Уушигны хатгаа 1
 8. Үжил-1

III. ЭХ, ХҮҮХДИЙН ЭРҮҮЛ МЭНД

- Нийт 268 эх төрж 267 хүүхэд мэндэлсэн нь өнгөрсөн онтой харьцуулахад 31 төрөлтөөр хүн амын төрөлт буурсан байна. Нийт төрсөн хүүхдийн хүйсийн харьцаа 1,1:1 байгаа ба эрэгтэй хүйс давамгайлж байна.
- Нийт төрөлтийн 5,6% / 15/ охидын төрөлт эзэлж байгаа нь анхаарал татаж байгаа үзүүлэлт байна./Шб-3,Өо-2, Эх-3/.
- 2 сарын байдлаар 97 эх үр хөндүүлж 1000 амьд төрөлтөд 363.2 байгаа нь өнгөрсөн оноос 27.7-р өссөн үзүүлэлт байна. Өсвөр насны охидын үр хөндөлт-13/13,4%/ Бд-2,Бу-1,Гт-1,Нн-1,Цо-2,Цц-2,Шб-1,Өо-1,Эх-2/ байна.
- Үр хөндөлт 1000 амьд төрөлтөд 27,7-р , охидын үр хөндөлт 5,5-р нэмэгдсэн байна.
- 2 сарын байдлаар сард дундажаар 5298 хүүхдийг идэвхтэй хянаж, хооллолт өсөлт хөгжилтийн байдлыг үнэлэн зөвлөгөө дэмжлэг үзүүлсэн нь хяналтад хамрагдвал зохих хүүхдийн 55,1% эзэлж байгаа нь хангалтгүй байна. Хяналтанд хамрагдсан хүүхдүүдээс 3 хүүхэд жингийн алдагдалтай байгаа нь нийт хүүхдийн 0,05%-г эзэлж байгаа ба 14 хүүхэд туранхай, 11 хүүхэд өсөлт хоцрогдолтой байна.
- 0-1 насны хүүхдийн хяналт 6-р нэмэгдэж, 1-5 хүртэлх насны хүүхдийн хяналт 0,6-р тус буурсан байна.

IV. ХАЛДВАРТ ӨВЧИН

- Он гараад 41 халдварт өвчин бүртгэж эмчилсэн нь өнгөрсөн оноос 101 тохиолдлоор буурсан байна. Нийт халдварт өвчний 4,8%-г салхинцэцэг, 4,8% сүрьеэ, 4,8%-г гар хөл амны өвчин, 7,3% цусан суулга, 51,2%-г БЗДХ өвчин тус тус эзэлж байна.
- БЗДХ-н 9.5% нь жирэмсний үзлэгээс, 19% нь урьдчилан сэргийлэх үзлэгээр, 47.6% нь өвчний учир амбулатороор, 23.8% нь тандалтын үзлэгээс илэрсэн байна.

ДЭЭРХ ҮЗҮҮЛЭЛТЭЭС ЦААШИД АНХААРАХ АСУУДАЛ

1. Охидын төрөлт, үр хөндөлт, БЗДХ өмнөх жилээс нэмэгдэх хандлагатай байгаад анхаарч өсвөр үеийн эрүүл мэнд, ялангуяа нөхөн үржихүйн эрүүл мэндийн боловсролыг сайжруулахад илүү үр дүнтэй ажил зохион байгуулах шаардлагатай.
2. Үр хөндөлт хүсээгүй жирэмслэлт нэмэгдсэн байгаад анхаарч нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүдийн дундах жирэмслэлтээс сэргийлэх аргын хэрэглээ, зорилтод бүлгийн хяналт, үр хөндөлтийн дараахь зөвлөгөө, давтан үр хөндөлтөөс сэргийлэх үйл ажиллагааг сайжруулах
3. Гэрийн 2 төрөлт нь алслагдсан хөдөө орон нутагт биш, аймгийн төв дээр тохиолдсон байгаа нь хөдөө орон нутгаас ирсэн эхчүүдийн хяналт, төрөх дөхсөн эхчүүдэд өгөх зөвлөгөө, мэдээллийг сайжруулах шаардлагатайг харуулж байна.
4. БЗДХ-н 80,9% нь идэвхгүй үзлэг тандалтаар илэрсэн байгаа нь хүн амын дундах өвчлөлийн тархалт өндөр байгааг харуулж байгаа ба урьдчилан сэргийлэх үзлэг, илрүүлэлтийг идэвхжүүлэх шаардлагатай.
5. Хүн амын өвчлөлийн тэргүүлэх шалтгаан болсон хоол боловсруулах эрхтэний болон зүрх судасны эмгэгийг бууруулах, урьдчилан сэргийлэх чиглэлээр иргэдийн эрүүл мэндийн боловсролыг сайжруулах, мэдээлэл сургалт сурталчилгааг идэвхжүүлэх
6. Осол гэмтлийн өвчлөл нас баралт өнгөрсөн оноос нэмэгдсэн байгаа ба өвчлөлийн 30%, нас баралтын 48,2% зам тээврийн осол байна. Мөн осол гэмтлийн өвчлөлийн 55% нь гадны шалтгаан, орчин нөхцөл, ажлын байрны аюулгүй ажиллагаатай, 14,5% хүчирхийллийн шалтгаантай байгаад анхаарч осол гэмтлийн өвчлөл нас баралтыг бууруулахад салбан дундын хамтын ажиллагааг сайжруулах шаардлагатай.
7. Нас баралтын голлох шалтгаан нь цусны эргэлтийн тогтолцооны эмгэг буюу тархинд цус харвалт, зүрхний ишемит эмгэг зэрэг сэргийлж болох эндэгдэл тэргүүлж байгаа ба эрт илрүүлэлт, хяналтыг сайжруулах шаардлагатайг харуулж байна.
8. 1 наснаас дээш насны хүүхдийн хяналтын хувь өнгөрсөн оноос буурч, тураал, өсөлт хоцрогдол нэмэгдэх хандлагатай байгаа нь ковидтой холбоотой эцэг эхийн эмнэлэгт хандалт болон сум өрхийн эмч нарын ажил ачаалал, отор нүүдэлтэй холбоотой байх талтай байна. Хүүхдийн хяналт, сургалт зөвлөгөөний үр дүнтэй аргуудыг хайх, хүүхдийн хяналтыг сайжруулахад анхаарах. / цахим хяналт, сургалт, сайн дурын идэвхтэн, салбар, эмнэлэг хоорондын уяалдаа, хамтын ажиллагааг сайжруулах гэх мэт/

Мэдээлэл бэлтгэсэн: ЭМГ-н статистикч Б. Мидэрсүрэн , Д. Гантогтох